

МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2009 оны 12 дугаар  
сарын 23-ны өдөр

№ 267

Улаанбаатар хот

“Банк бус санхүүгийн байгууллагаас төвлөрүүлэх зохицуулалтын  
үйлчилгээний хөлсний хэмжээг тооцох журам” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 6.1.5, Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 5.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Банк бус санхүүгийн байгууллагаас төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тооцох журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэ журмыг 2010 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны “Банк бус санхүүгийн байгууллагаас төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 122 дугаар тогтоол, 2007 оны “Банк бус санхүүгийн байгууллагаас төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тооцох аргачлалыг батлах тухай” 144 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4. Журам батлагдсантай холбогдуулан Банк бус санхүүгийн байгууллагуудаас 2010 онд жил бүр төвлөрүүлбэл зохих зохицуулалтын үйлчилгээний хөлсийг 2010 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн дотор Хорооны холбогдох дансанд төвлөрүүлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/-т үүрэг болгосугай.

5. Батлагдсан журмын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

*/Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 3 дугаар сарын  
28-ны өдрийн 87, 2011 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 109 дүгээр  
тогтоолуудаар орсон өөрчлөлтүүдийг тусгав/*

Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 12 дугаар сарын  
23-ны өдрийн 267 дугаар тогтоолын хавсралт

## БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГААС ТӨВЛӨРҮҮЛЭХ ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСНИЙ ХЭМЖЭЭГ ТООЦОХ ЖУРАМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь банк бус санхүүгийн байгууллага /цаашид “ББСБ” гэх/-аас Хороонд төвлөрүүлбэл зохих зохицуулалтын үйлчилгээний хөлс /цаашид “зохицуулалтын үйлчилгээний хөлс” гэх/-ний хэлбэрийг тодорхойлох, хэмжээг тооцох болон бусад холбогдох харилцааг зохицуулахад оршино.

### ХОЁР. ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСНИЙ ХЭЛБЭР, ТӨВЛӨРҮҮЛЭХ ХУГАЦАА

2.1. Зохицуулалтын үйлчилгээний хөлс нь жил бүр төвлөрүүлэх, тухай бүр төвлөрүүлэх гэсэн 2 хэлбэртэй байна.

2.2. Жил бүр төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсийг ББСБ-ын өмнөх оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан тэнцэл дэх өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө /цэврээр/, хуримтлуулж тооцсон хүүгийн авлагыг хасаж тооцсон нийт активын дүнгээс энэ журмын 3.1-д заасан ангиллын дагуу тооцож, тухайн оны жилийн тайлант хугацааны 5 дугаар сарын 01-ний өдрийн дотор Хорооны холбогдох дансанд төвлөрүүлсэн байна.

2.3. Тухай бүр төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлс нь нэг удаагийн шинжтэй үйл ажиллагаанаас авах хөлс бөгөөд уг хөлсийг авахдаа энэ журмын 3.2-т заасан хэмжээгээр, холбогдох өөрчлөлтийн талаарх Хорооны шийдвэр гарснаас хойш, уг шийдвэрийг хэлбэржихээс өмнө Хорооны холбогдох дансанд төвлөрүүлсэн байна.

### ГУРАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСНИЙ ХЭМЖЭЭ

3.1. Жил бүр төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг дараах байдлаар тогтооно:

| № | Нийт активын дүн                              | Хороонд төвлөрүүлбэл зохих зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ /төгрөгөөр/ | Нэмэлт мэдээлэл   |
|---|---|--|---|
| 1 | 4,000,000,001 төгрөгөөс дээш                  | 2,600,000  | Улаанбаатар хотын Налайх, Багануур, Багахангай дүүрэг, аймгийн төвийн сумын |
| 2 | 2,000,000,001-ээс 4,000,000,000 төгрөг хүртэл | 2,200,000  |   |
| 3 | 1,000,000,001-ээс 2,000,000,000 төгрөг хүртэл | 1,600,000  |   |

|   |   |           |  |
|---|---|-----------|--|
| 4 | 600,000,001-ээс 1,000,000,000 төгрөг хүртэл | 1,200,000 | нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа бол 10 хувиар, аймгийн                              |
| 5 | 400,000,001-ээс 600,000,000 төгрөг хүртэл   | 800,000   |  |
| 6 | 200,000,001-ээс 400,000,000 төгрөг хүртэл   | 600,000   | төвийн сумаас бусад суманд үйл ажиллагаа явуулж байгаа бол 20 хувиар тус тус хөнгөлөлт үзүүлнэ |
| 7 | 100,000,001-ээс 200,000,000 төгрөг хүртэл   | 300,000   |  |
| 8 | 10,000,001-ээс 100,000,000 төгрөг хүртэл    | 150,000   |  |

3.2. Тухай бүр төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг дараах байдлаар тогтооно:

| №   | Хороонд төвлөрүүлбэл зохих зохицуулалтын үйлчилгээний төрөл  | Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ /төгрөгөөр/ | Нэмэлт мэдээлэл  |
|---|--|---|--|
| 1   | 1.1 Зээлийн үйл ажиллагаа эрхлэх   |   | Анх удаа тусгай зөвшөөрөл авах болон нэмж тусгай зөвшөөрөл авахад тус тус хамаарна |
|   | 1.1.1 Аймгийн төвийн сумаас бусад суманд   | 20,000  |  |
|   | 1.1.2 Аймгийн төвийн сум   | 50,000  |  |
|   | 1.1.3 Улаанбаатар хотын Налайх, Багануур, Багахангай дүүрэг, Дархан-Уул аймгийн Дархан сум, Орхон аймгийн Баян-Өндөр сум | 200,000   |  |
|   | 1.1.4 Улаанбаатар хотын бусад дүүрэг   | 400,000   |  |
|   | 1.2 Факторингийн үйлчилгээ эрхлэх  | 150,000   |  |
|   | 1.3 Төлбөрийн баталгаа гаргах үйлчилгээ эрхлэх   | 150,000   |  |
|   | 1.4 Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах үйлчилгээ эрхлэх   | 1,000,000   |  |
|   | 1.5 Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх  | 1,000,000   |  |
| 1.6 Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх         | 150,000  |   |  |
| 1.7 Итгэлцлийн үйлчилгээ эрхлэх                           | 1,000,000  |   |  |
| 1.8 Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт | 1,000,000  |   |  |

|   |   |           |   |
|---|---|-----------|---|
|   | 1.9 хийх  |           |   |
|   | 1.10 Хоронго оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх   | 50,000    |   |
|   | 1.10 Хөрөөнөөс олгосон бусад үйл ажиллагаа эрхлэх   | 150,000   |   |
| 2 | Салбар байгуулах зөвшөөрөл олгох бүр тухайн салбарын тоогоор:   |           | Улаанбаатар хотын Налайх, Багануур, Багахангай дүүрэг болон бусад аймаг, сумын нутаг дэвсгэрт байгуулагдсан ББСБ нь Улаанбаатар хотын дээр дурдсан 3 дүүргээс бусад дүүрэгт салбараа нээх тохиолдолд 200,000 төгрөгөөр тооцож төвлөрүүлнэ           |
|   | 2.1 Улаанбаатар хотын Налайх, Багануур, Багахангай дүүргээс бусад дүүргүүдэд  | 200,000   |   |
|   | 2.2 Улаанбаатар хотын Налайх, Багануур, Багахангай дүүрэг болон бусад аймаг, сумдад                                       | байхгүй   |   |
| 3 | Төлөөлөгчийн газар байгуулах зөвшөөрөл олгох бүр тухайн төлөөлөгчийн газрын тоогоор:                                      |           | Улаанбаатар хотын Налайх, Багануур, Багахангай дүүрэг болон бусад аймаг, сумын нутаг дэвсгэрт байгуулагдсан ББСБ нь Улаанбаатар хотын дээр дурдсан 3 дүүргээс бусад дүүрэгт төлөөлөгчийн газраа нээх тохиолдолд 50,000 төгрөгөөр тооцож төвлөрүүлнэ |
|   | 3.1 Улаанбаатар хотын Налайх, Багануур, Багахангай дүүргээс бусад дүүргүүдэд  | 50,000    |   |
|   | 3.2 Улаанбаатар хотын Налайх, Багануур, Багахангай дүүрэг болон бусад аймаг, сумдад                                       | байхгүй   |   |
| 4 | Өнөөсөн нэр оорчлох   | 2,000,000 | Хөрөөнөөс тавьсан шаардлагын дагуу оорчилсон тохиолдолд тооцохгүй   |
| 5 | Компанийн хэлбэрээ оорчлох, нийлэх, нэгдэх, хуваах, тусгаарлах, оорчлох замаар оорчлон байгуулагдах                       | 200,000   | -   |
| 6 | ББСБ-ын оорийн буруугаас үрэгдүүлж, гэмтээсэн тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, гэрчилгээний хавсралтыг солих, шинэчлэн олгох | 200,000   | Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, гэрчилгээний хавсралтыг хамтад нь солих, шинэчлэн олгох тохиолдолд 200,000 төгрөг, аль нэгийг нь сольж, шинэчлэх тохиолдолд тус бүр 100,000 төгрөг байна.   |

|   |  |                                       |   |
|---|--|---------------------------------------|---|
|   |  |                                       | Үрэгдүүлснээс бусад тохиолдолд гэрчилгээг солих, шинэчлэн авах хүсэлтээ<br>Хороонд ирүүлэхдээ тусгай зөвшөөрлийн гэрчилгээ болон гэрчилгээний хавсралтын эх хувийг ирүүлсэн байна |
| 7 | Хууль тогтоомж, журам, зааварт заасан бусад  | Хорооны шийдвэрээр тухай бүр тогтооно | -   |
| 1 | ББСБ-ын өөрийн буруугаас үрэгдүүлсэн эсхүл гэмтээсэн тусгай зөвшөөрлийн гэрчилгээ солих, шинэчлэн олгох<br>ББСБ-ын өөрийн буруугаас үрэгдүүлсэн эсхүл гэмтээсэн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралт солих, шинэчлэн олгох | 100,000<br><br>100,000                | Үрэгдүүлснээс бусад тохиолдолд гэрчилгээг солих, шинэчлэн авах хүсэлтээ<br>Хороонд ирүүлэхдээ тусгай зөвшөөрлийн гэрчилгээ болон гэрчилгээний хавсралтын эх хувийг ирүүлсэн байна |
| 7 | Хууль тогтоомж, журам, зааварт заасан бусад  | Хорооны шийдвэрээр тухай бүр тогтооно | -   |

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 87 дугаар тогтоолоор өөрчилсөн/*

|   |  |         |                 |
|---|--|---------|-----------------|
| 8 | Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээх  | 200,000 |                 |
| 9 | Дүрэм болон бусад өөрийн мэдээллийг Хорооны архиваас хулбарлан нөхөн авах болон бусад үйлчилгээ үзүүлэхэд төлөх хөлс | 1,000   | Нэг нүүр хуудас |

*/Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 109 дүгээр тогтоолоор нэмсэн/*

## ДӨРӨВ. ХАРИУЦЛАГА

4.1. Зохицуулалтын үйлчилгээний хөлсийг төлөх хугацааг аливаа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хугацаа хэтрүүлсэн тохиолдолд холбогдох хууль тогтоомж, заавар, журмын дагуу хариуцлага хүлээлгэх ба 3 сар ба түүнээс дээш хугацаагаар хэтрүүлсэн тохиолдолд Хорооны 2008 оны 186 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-д заасан хариуцлагыг хүлээлгэнэ.